



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: “ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

**Аудит хийсэн
үндэслэл,
бүрэн эрх:**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3, 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд, Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэв.

АУДИТЫН ГОЛ ДҮГНЭЛТ: “ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУСГАЙЛСАН БОДЛОГО ТОДОРХОЙЛООГУЙ, ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАНГАЛТГҮЙ БАЙНА”

**Аудитын
тайланг
хүргүүлсэн:**

ҮАГ-ын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар, Аймгийн ИТХ, Засаг дарга, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар-т тус тус хүргүүлсэн.

Дархан-Уул аймаг

2024 оны 10 дугаар сар

**Аудитын
зорилт**

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт болон бий болсон үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан Улсын Их Хурлын байнгын хороо, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго оршино.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, төлөвлөлтийн тогтолцоо оновчтой эсэх;
- Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт үр өгөөжтэй, хүүхдэд ээлтэй байж чадсан эсэх;
- Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт үр дүнтэй эсэх

**Аудитын
хамарсан
хүрээ**

Аудитад Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд хүүхэд хамгааллын чиглэлээр, үйл ажиллагаанд оролцдог төрийн болон төрийн бус байгууллагуудын 2019-2023 оны баримт, мэдээллийг хамруулан аудитыг гүйцэтгэлээ.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр удирдаж, аудитын менежер У.Батсүрэн үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор С.Батцэцэг, аудитор Б.Алтанзул, Г.Батмягмар, Э.Одгэрэл нар гүйцэтгэсэн.

**Аудит хийхэд
гарсан
хүндрэл
бэрхшээл**

Аудитад хүндрэл бэрхшээл гараагүй болно.

НЭГ. ОРОН НУТГИЙН ХЭМЖЭЭНД ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУСГАЙЛСАН БОДЛОГО ТОДОРХОЙЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ХҮҮХДЭД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨЖ, ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

Дархан-Уул аймгийн ХГБХХГ-ын 2019-2023 онд хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээг хөгжлийн бодлогын урт, дунд, богино хугацааны баримт бичгүүдтэй хүүхэд хамгааллын чиглэлээр тусгасан зорилт, арга хэмжээ харилцан уялдаатай байна гэж дүгнэлээ.

Хүүхэд бүрийн онцлогоос хамаарсан тусгай хэрэгцээт, үл хайхрагдсан, өрх толгойлсон хүүхэд зэргээр нь тодорхойлж төлөвлөсөн арга хэмжээ байхгүй байна.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХҮРЭЛЦЭЭ ДУТМАГ БАЙНА

Тус байгууллагын 2019-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, холбогдох баримт материалтай танилцаж, судлан үзэхэд дээрх хуульд заасан үйл ажиллагаануудыг гүйцэтгэх чиг үүргийн дагуу хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд хамгааллын талаарх мэдээлэл, судалгаанд нэгдсэн дүгнэлт хийж, цаашид хийх ажлын чиглэлийг тодорхойлох ажил дутмаг байв.

Аудитаар аймгийн хэмжээнд одоогийн байдлаар нийт 58 нийгмийн ажилтан ажиллаж байгаагаас 15.5 хувь нь газар зохион байгуулагч, бага эмч, нягтлан бодогч, сэтгүүлч, эдийн засагч, программ хангамжийн инженер зэрэг мэргэжилтэй 9 хүн сумдын ЗДТГ-т багийн нийгмийн ажилтнаар ажиллаж байна. Энэ нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Хүүхэд хамгааллын чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллага болон хуулийн этгээд тусгайлан бэлтгэгдэж, мэргэшсэн хүний нөөцтэй байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Төрийн үйлчилгээний албан тушаалд хамаарах мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургуулиудын мэргэжлийн шаардлагыг нийгмийн ажилтнаар тодорхойлж баталжээ.

Харин төрийн захиргааны албан тушаал буюу сумын ЗДТГ-ын багийн нийгмийн ажилтны албан тушаалын сонгон шалгаруулалтыг зарлахдаа мэргэжлийн шаардлагад “..., сэтгүүл зүй, бизнес, удирдлага, мэдээлэл, харилцаа холбооны технологи, бусад” гэж заасан тул шалгалтад ямар ч мэргэжлийн хүн хамрагдаж, томилогдохоор нөхцөл бүрдсэн байна.

Иймд Төрийн албаны зөвлөлөөс төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг хянан батлахдаа төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах мэргэжлийн шаардлагыг тухайн албан тушаалын чиг үүрэгт нийцүүлсэн эсэхийг нягтлан үзэх нь зүйтэй гэж үзлээ.

БҮЛЭГ 2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ХҮРТЭЭМЖТЭЙГЭЭР ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР 2019-2023 ОНД ТӨЛӨВЛӨГДСӨН САНХҮҮЖИЛТИЙГ 99.1 ХУВИЙГ ЗАРЦУУЛСАН БАЙНА

Дархан-Уул аймгийн хэмжээнд эрсдэл нөхцөлд байгаа хүүхдийн тоо 2023 оны байдлаар 754 болж өнгөрсөн оноос 281.3 хувиар өссөн нь цаашид эрсдэлээс

урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, сургалт нөлөөллийн ажлыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Аймгийн ХГБХХГ нь хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт, нөлөөлөл, хуулийн зөвлөгөө өгөх ажлыг магадлан итгэмжлэгдээгүй дараах байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан байна. Үүнд:

- “Аз жаргалын дасгалжуулагч” НҮТББ-тай -4.4 сая,
- “Гэрэлт зам үзэг” НҮТББ-тай - 3.1 сая,
- “Монголын урлагийн сэтгэл заслын мэргэжлийн холбоо”-той -4.9 сая,
- “Хайраас өвлөх хайр холбоо” НҮТББ-тай -2.4 сая,
- “Хөгжилтэй алаг үрс” НҮТББ-тай - 0.6 сая,
- Дархан-Уул аймгийн Эмэгтэйчүүдийн холбоотой– 4.1 сая,
- “Сэтгэл судлалын багш нарын холбоо”-той -6.2 сая төгрөгийн гэрээ байгуулан ажилласан байна.

Энэ нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/128 дугаар тушаалаар баталсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.7¹-д заасан заалттай нийцэхгүй байгаа тул цаашид урьдчилан сэргийлэх, хууль сурталчлах, соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлыг магадлан итгэмжлэгдсэн байгууллагатай хамтран ажиллахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

ХҮҮХЭД ХАМГААЛАЛД ТӨЛӨВЛӨСӨН САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ СУЛ, ҮР ДҮНГ ТООЦООГҮЙ АЖЛУУД БАЙНА

ХГБХХГ-аас жил бүр хурдан морины уралдаан зохион байгуулах бүрд хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хурдан морины уралдаанч хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавих, уралдаанч хүүхдүүдийн бүртгэл хийхэд зориулан нийт 7.0 сая төгрөгийг хүүхэд хамгааллын зардлаас олгож ирсэн байна.

Цаашид хурдан морины уралдаан зохион байгуулах зардлыг хүүхэд хамгааллын зардлаас бус тус уралдааныг зохион байгуулж байгаа комиссоор гаргуулж байх нь зүйтэй гэж үзлээ.

2019 онд хүүхэд хамгааллын зардлаас архивын ажилтныг чадавхжуулах сургалтад 0.08 сая төгрөгийг, анхан шатны баримтаар дэмжигдээгүй 0.2 сая төгрөгийн шатахууны зардал гаргасан зэрэг зөрчилд төлбөрийн акт тогтоов.

Аймгийн ХГБХХГ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас “Нарны хүүхдүүд” асрамж, халамжийн төвд олгож байгаа хүүхдийн хоол болон хувцас, ариун цэврийн болон хичээлийн хэрэглэл, зөөлөн эдлэлийн зардлын санхүүжилтийг үнэн зөв олгож байгаа эсэхийг асрамжийн төвөөс ирүүлсэн хүүхдийн бүртгэл, боловсролын мэдээллийн сан, норм нормативыг үндэслэн тулган шалгалаа. Тулгалтаар 1 хүүхдийн мэдээлэл аймгийн боловсролын мэдээллийн санд бүртгэлгүй байсныг тухайн хүүхдийн анги удирдсан багшийн хайхрамжгүй байдлаас болж бүртгэлээс хассаныг бүртгэлд нөхөн оруулж, хүүхдийн эрхийн улсын байцаагчаар дамжуулан тухайн сургууль, багшид арга хэмжээ авч ажилласан.

Мөн асрамжийн төвд амьдарч байгаа хүүхдүүдийн бүртгэлийг тулгахад “Монголын СОС-ын хүүхдийн хотхон” асрамжийн төвд 1, “Нарны хүүхдүүд”

¹ “Хүүхэд хамгааллын үйлчилгээг төрийн байгууллага, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллага буюу магадлан итгэмжлэгдсэн байгууллага үзүүлнэ”

асрамжийн төвд 16 хүүхдийг тухайн шатны Засаг даргын захирамжаар шилжүүлээгүй байна. Энэ нь Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10², 66 дугаар зүйлийн 66.1³, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/209 дугаар тушаалаар батлагдсан “Хүүхэд асрах хувилбарт, үйлчилгээ үзүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3⁴ дахь заалттай нийцэхгүй байна.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас “Нарны хүүхдүүд” асрамжийн төвд амьдарч буй хүүхдүүдэд олгосон санхүүжилтийг Сангийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2016 оны 52/А/20 дугаар тушаал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын 2021 оны А/188 дугаар тушаалаар баталсан “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын дундаж норматив”, “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хувцас, ариун цэврийн болон хичээлийн хэрэглэлийн зардлын дундаж норматив”-д заасны дагуу олгосныг тулган шалгахад 2023 оны хувьд 37.7 сая төгрөгийг илүү олгосон байв.

Аймгийн ХГБХХГ-ийн хүүхдийн эрхийн улсын байцаагч “Нарны хүүхдүүд” асрамж, халамжийн төвд амьдарч байгаа хүүхдийн тоон мэдээлэлд хяналт тавилгүй санхүүжилтийг олгосон байна.

БҮЛЭГ 3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ХУУЛИАР ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН САЛБАР БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО ХАНГАЛТГҮЙ БАЙНА

АЙМГИЙН ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗӨВЛӨЛ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА

Аудитаар ГБХЗХГ-ын даргын тушаалаар баталсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх заавар, аргачлалын дагуу дүгнэж, үнэлснээс 2023 оны байдлаар түр хамгаалах байрны үйл ажиллагаа, “Цэцэг шиг нас” ТББ нарын үнэлгээ буурсан нь зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавиагүйгээс шалтгаалжээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/122 дугаар тушаалаар баталсан “Насан хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт батлах тухай” журмын хэрэгжилт хангалтгүйгээс Дархан-Уул аймагт насанд хүрээгүй хүүхдийг хориглосон ажлын байранд ажиллуулснаас хөдөлмөр эрхэлж байхдаа нас барсан тохиолдол 2024 оны 8 дугаар сард бүртгэгдсэн харамсалтай хэрэг гарсан байна. Иймд хяналт шинжилгээ үнэлгээгээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах, хориглосон ажлын байранд хүүхэд ажиллуулж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Байгууллагын үйл ажиллагаандаа НҮБ-ын хүүхдийн эрхийн хорооноос хүргүүлсэн 7 зөвлөмж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 28

² “Хүүхдийг энэ хуулийн 25.9-д заасны дагуу шилжүүлэх боломжгүй бол сум, дүүргийн Засаг дарга нь асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох, үрчлүүлэх, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ”

³ “Энэ хуулийн 63, 64 дүгээр зүйлд заасан хүнийг судлан тогтоох, түүнд хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч томилох, асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлыг шийдвэрлэх үүргийг сум, дүүргийн Засаг дарга хэрэгжүүлнэ”

⁴ “Төвлөрсөн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах шийдвэрийг Хамтарсан багийн нөхцөл байдлын үнэлгээ, хурлын шийдвэр, тухайн аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга гаргана. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын дүгнэлтэд үйлчилгээнд хамруулах үндэслэлийг тодорхой тусгасан байна.”

дугаар зүйлийн 28.4⁵ дэх заалт тусгайлан заасан чиг үүргийг ижил агуулга, нэршлээр нь нэгтгэн тодорхойлох байдал хангалтгүй.

Аймгийн хүүхдийн төлөө зөвлөл нь 2019-2020 онд төлөвлөгөө гарган батлуулсан боловч 2021-2023 онд төлөвлөгөө гаргаагүй, 2019, 2023 онд хийсэн ажлын тайлан гаргаж, 2020-2022 онд гүйцэтгэсэн ажлын тайлан гаргаагүй, 2019 онд хүүхдийн төлөө зөвлөлийг хуралдуулж, тайланг хэлэлцсэн ба бусад онд хуралдаагүй бөгөөд 2019-2023 онд аймгийн ИТХ-аар тайлангаа хэлэлцүүлээгүй.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ХУУЛИАР ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН САЛБАР БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО ХАНГАЛТГҮЙ БАЙНА

ХГБХХГ-ын авсан судалгаагаар Хүүхэд хамгааллын төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолын⁶ дагуу 2023 онд төрийн 101, хувийн хэвшлийн 71 байгууллага "Эцэг эхийн зөвлөл" байгуулсан нь 4 жилийн хугацаанд 7 хувиар өссөн нь тогтоолын хэрэгжилт, ХЭУБ хамтарсан багийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийсэн боловч зөвлөмжийг албан бичгээр өгдөггүй, багийн урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнээгүй, хувийн хэрэг хөтлөлт, нууцлал хангаагүй, нууцын гэрээний хадгалалтын шаардлагад нийцээгүй зэрэг ажлын хэрэгжилт, түүвэрт хамрагдсан 7 хамтарсан багийн нийгмийн ажилтнаас тодруулга авч холбогдох баримт бичгийг шалгахад томилогдсон эмч ажлын ачааллаас ихтэйгээс оролцоо, өрхийн эмч нарын шилжилт хөдөлгөөн ихтэй зэргээс шалтгаанаас эмч нарын оролцоо зэрэг үйл ажиллагаа хангалтгүй байна.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ ҮР ДҮНГҮЙ БАЙНА

Аймгийн хэмжээнд дээрх гэмт хэрэг гарч байгаатай холбоотойгоор гэмт хэрэгт өртсөн хүүхдүүдэд шаардлагатай арга хэмжээг авч, урьдчилсан сэргийлэх талаар хийсэн ажлыг авч үзвэл хүүхэд, залуучуудад гэмт хэрэг, зөрчил, эрүүл мэнд, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хувь хүний хөгжил, цахим орчны зохистой хэрэглээ, хүчирхийллийг үл тэвчих, нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зэрэг сургалт, нөлөөллийн арга хэмжээ хэрэгжүүлж байгаа хэдий ч гэмт хэрэгт өртсөн хүүхдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх ажил хийгдэхгүй байгаа харагдаж байна.

Хүүхэд хамгаалах хариу үйлчилгээ авсан хүүхдүүдийн хүчирхийллийн хэлбэрээр авч үзвэл 51.2 хувийг үл хайхрах хүчирхийлэл эзэлж байна.

Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэгт холбогдуулахгүй байх, гэмт хэргийн хохирогч болгохгүй байх чиглэлийн хүрээнд олон талт арга хэмжээг жил бүр төлөвлөгөөнд тусган, хамтрагч байгууллагуудтай хамтран сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байгаа хэдий ч гэмт хэрэгт өртсөн хүүхдийн тоо буурахгүй байна. Энэ нь Эцэг, эх гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах, түүнийг шийдвэрлүүлэх замаар ээлтэй орчныг бүрдүүлээгүйгээс шалтгаалжээ.

⁵ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, бүх төрлийн дарамт, мөлжлөгт өртөх, гэмт хэргийн хохирогч болох, гэмт хэрэгт татагдан орох зэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хууль сахиулах, хүүхдийн эрхийг хамгаалах, боловсролын болон төрийн эрх бүхий холбогдох байгууллага хэрэгжүүлнэ

⁶ Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 тогтоолоор баталсан

ДҮГНЭЛТ:

- Орон нутгийн хэмжээнд тусгай хэрэгцээт хүүхдэд чиглэсэн арга хэмжээ болон хүүхэд хамгааллын үйл ажиллагааны мэдээллийн сан бүрдээгүй, хүний нөөцийн хүрэлцээ дутмаг байна
- “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг шинээр баталснаар хүүхэд хамгааллын зардлын төсвийг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн хуваарилан зарцуулсан, төсөвлөсөн нийт зардлын 331.1 сая төгрөг буюу 53.2 хувийг хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд тус тус зарцуулсан байна
- Олон улсын байгууллагын нийт 185.0 сая төгрөгийн зээл, тусламжийн хөрөнгийг бүртгэж, тайлагнасан байна
- Аймгийн хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн хүүхдийн асрамж, халамжийн 2 байгууллагад 96 хүүхдийг асрах, хамгаалах үйлчилгээг тогтмол үзүүлж байна
- Хүүхдийн төлөө зөвлөл болон эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээг бодитой хийж үнэн зөв тайлагнаагүй байна
- Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлж нийгэмд гарч буй эерэг нөлөөг тооцож үнэлээгүй ч хүүхдийн төлөө хийгдсэн онцлох ажлууд их байна
- Хүүхэд хамгааллын талаар хуулиар үүрэг хүлээсэн салбар байгууллагын оролцоо хангалтгүй байна
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх заавар, аргачлалын дагуу дүгнэж, үнэлдэг боловч зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгахгүй байна
- НҮБ-ын хүүхдийн эрхийн хорооны 5 дугаар тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байгаа боловч хуулиар тусгайлан заасан чиг үүргийг бүрэн төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай байна
- Эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээг түргэн, шуурхай хүргэж, стандартад нийцсэн түр хамгаалах байраар үйлчилж байна
- Хуулиар үүрэг хүлээсэн салбар байгууллагууд хүүхэд хамгаалалтай холбоотой тоон үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, үр дүнг тооцож ажиллах шаардлагатай байна

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн Засаг дарга, Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн Б.Азжаргал танаа:

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заалтын дагуу тусгайлан заасан чиг үүргийг, хуулиар үүрэг хүлээсэн салбар байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хүүхэд хамгааллын талаар арга хэмжээг бүрэн төлөвлөж, үр дүнг тооцож байх

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга А.Амгалан танаа:

Хүүхэд хамгааллын талаарх мэдээ мэдээлэл, судалгаанд дүгнэлт хийж, цаашид хийх ажлын чиглэлийг тодорхойлж, хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлж, хохирогч хүүхдийн хувийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахгүй байх

Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх эрх бүхий магадлан итгэмжлэгдсэн байгууллагын үйлчилгээ үзүүлэхэд анхаарч ажиллах, “Нарны хүүхдүүд” асрамж, халамжийн төвд хүүхдийн хоолны хувьсах зардлын санхүүжилтийг хүүхдийн эрхийн улсын байцаагчийн хянасан тоо мэдээнд үндэслэн олгож байх

Хурдан морины уралдаан зохион байгуулахад хяналт тавьж байгаа зардлыг хүүхэд хамгааллын зардлаас бус Улсын баяр наадмаас бусад хурдан морины уралдааныг зохион байгуулж байгаа комиссоор гаргуулж уралдаанч хүүхдүүдийн бүртгэлийг хийж, хүүхдийн аюулгүй байдал, тухайн шатны Засаг даргын захирамжаар хүүхдийн асрамжийн төвд шилжүүлж байгаа эсэхэд, насан хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байранд байнгын хяналт тавьж ажиллах

Аймгийн хүүхдийн төлөө зөвлөл нь төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг ханган тайланг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэх

Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр илэрсэн алдаа, зөрчил өгсөн зөвлөмжийн биелэлтийг тооцож, шаардлагатай тохиолдолд шуурхай хариу арга хэмжээ авч ажиллах

Эрсдэлт нөхцөлд орсон хүүхдийн гэр бүл, асран хамгаалагчдад сургалт, нөлөөллийн ажлыг үр дүнтэй болгох, Гэмт хэрэгт өртсөн хүүхдийг эрсдэлт нөхцөл байдлаас хамгаалах, урьдчилсан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга С.Энхболд танаа:

“Нарны хүүхдүүд” асрамж, халамжийн төвд орон нутгийн халамжийн сангаас олгох хувьсах зардлын санхүүжилтийг батлагдсан аргачлал нормын дагуу тооцож олгох, санхүүжилтэд дотоод хяналтыг сайжруулж ажиллах

Аудитын явцад илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аймгийн Засаг дарга	2	-	-	-	-	-	2	-	-	-
Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	14	-	1	295.0	-	-	13	-	-	-
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	1	-	-	-	-	-	1	37,745.8		
Дүн	17	38,040.8	1	295.0	-	-	16	37,745.8	-	-